



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (412)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он

4/12



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны наймдугаар сарын 21

№31 (412)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|-----|
| 903. | Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай | 666 |
| 904. | Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 671 |
| 905. | Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 671 |
| 906. | Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай | 672 |
| 907. | Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай | 673 |
| 908. | Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 673 |
| 909. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 673 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|-----------|-----|
| 910. | Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай | Дугаар 48 | 674 |
|------|--|-----------|-----|

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 911. | Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 33 | 682 |
|------|---|-----------|-----|

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|-----|
| 912. | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 147 | 682 |
|------|--|------------|-----|



2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ИПОТЕКИЙН ЗҮЙЛИЙГ ШҮҮХИЙН БУС ЖУРМААР ХУДАЛДАН БОРЛУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь банк, банк бус санхүүгийн байгууллагатай зээлийн болон барьцааны гэрээ байгуулсан зээлдэгч зээлийн гэрээний үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль тогтоомж

2.1. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль³, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль⁴, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Банк, банк бус санхүүгийн байгууллага /цаашид "зээлдүүлэгч" гэх/-аас бусад иргэн ба хуулийн этгээдийн зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбогдуулан ипотекийн зүйлийг худалдан борлуулах ажиллагаанд энэ хуулийн зохицуулалт үл хамаарна.

3.2. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлд ипотекоор хангагдах шаардлага бүхий хоёр

ба түүнээс дээш этгээд бүртгэгдсэн бол энэ хуулийн зохицуулалт үл хамаарна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүсэх

4 дүгээр зүйл. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүсэх үндэслэл

4.1. Зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд зээлдүүлэгчийн энэ хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шаардлага нь ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа үүсэх үндэслэл болно.

5 дугаар зүйл. Гэрээний үүрэг гүйцэтгэх тухай шаардлага

5.1. Зээлдэгч гэрээнд заасан үүргээ хугацаанд нь гүйцэтгээгүй бол зээлдүүлэгч зээлийн үүрэг гүйцэтгэх тухай шаардлага /цаашид "шаардлага" гэх/-ыг бичгээр гаргана.

6 дугаар зүйл. Шаардлагын агуулга

6.1. Шаардлагад түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор үүргээ гүйцэтгэхийг зээлдэгчид сануулах ба энэ хугацаанд зээлийн үүргээ гүйцэтгээгүй нь ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааг үргэлжлүүлэх үндэслэл болох талаар заавал тусгана.

7 дугаар зүйл. Шаардлага гардуулах

7.1. Дор дурдсан тохиолдолд шаардлагыг гардуулсан гэж үзнэ:

7.1.1. зээлдэгчид өөрт нь гардуулсан;

¹ Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

7.1.2.зээлдэгчид өөрт нь гардуулах боломжгүй байсан бол гэрээнд заасан, эсхүл Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн алба/цаашид "Эрхийн улсын бүртгэлийн алба" гэх/-нд бүртгүүлсэн хаягаар нь шаардлагыг баталгаат шуудангаар хүргүүлсэн;

7.1.3.энэ хуулийн 7.1.2-т зааснаар шаардлагыг гардуулж чадаагүй тохиолдолд үндэсний хэмжээний өдөр тутмын сонинд нийтлүүлсэн.

7.2.Энэ хуулийн 7.1.3-т заасан сонинд нийтлүүлэх шаардлага нь сонини нүүрийг найм хуваасны нэгээс багагүй хэмжээтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааг бүртгэх

8 дугаар зүйл. Худалдан борлуулах ажиллагааг бүртгүүлэх тухай хүсэлт гаргах

8.1.Шаардлагыг энэ хуулийн 7.1-д заасны дагуу гардуулсан боловч зээлдэгч энэ хуулийн 6.1-д заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол зээлдүүлэгч Эрхийн улсын бүртгэлийн албанд ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааг бүртгүүлэх тухай хүсэлтийг бичгээр гаргана.

8.2.Энэ хуулийн 8.1-д заасан хүсэлтэд дараахь зүйлийг хавсаргана:

8.2.1.зээлийн болон барьцааны гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хувь;

8.2.2.энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагын хувь;

8.2.3.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу зээлдэгчид шаардлага гардуулсныг нотлох баримт;

8.2.4.энэ хуулийн 6.1-д заасан хугацаа өнгөрсөн боловч зээлдэгч зээлийн үүргээ гүйцэтгээгүйг нотлох баримт;

8.2.5.энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан дуудлага худалдааны зарын төсөл.

9 дүгээр зүйл. Худалдан борлуулах ажиллагааг бүртгэх

9.1.Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуулийн 8.1-д заасан хүсэлтийг хүлээн авч, ажлын

гурван өдөрт багтаан улсын бүртгэлд бүртгэнэ.

9.2.Эрхийн улсын бүртгэлийн алба зээлдүүлэгчийн гаргасан хүсэлт нь энэ хуулийн 8.2-т заасан шаардлагыг хангаагүй бол бүртгэхээс татгалзаж, энэ талаар зээлдүүлэгчид албан бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Дуудлага худалдаа

10 дугаар зүйл. Худалдан борлуулах арга

10.1.Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад нээлттэй дуудлага худалдааны аргыг хэрэглэнэ.

11 дүгээр зүйл. Худалдан борлуулах ажиллагааг зогсоох

11.1.Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ дуудлага худалдаа эхлэхээс өмнө гүйцэтгэсэн бол худалдан борлуулах ажиллагааг зогсоох тухай хүсэлтийг зээлийн үүргээ гүйцэтгэсэн талаархи нотлох баримтын хамт Эрхийн улсын бүртгэлийн албанд гаргана.

11.2.Зээлдэгч энэ хуулийн 11.1-д заасны дагуу хүсэлт гаргасан бол дуудлага худалдааг явуулахгүй.

11.3.Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуулийн 11.1-д заасан зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн ажлын гурван өдөрт багтаан худалдан борлуулах ажиллагааны бүртгэлийг хааснаар уг ажиллагааг зогсоно.

12 дугаар зүйл. Дуудлага худалдааны зар

12.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол дуудлага худалдааны зарыг түүнийг явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө үндэсний хэмжээний өдөр тутмын хоёроос доошгүй сонинд нийтлүүлэх бөгөөд шаардлагатай бол дахин нийтлүүлж болно.

12.2.Дуудлага худалдааны зард дор дурдсан зүйлийг заавал тусгана:

12.2.1.ипотекийн зүйлийн байршил;
12.2.2.ипотекийн зүйлийн зориулалт;

12.2.3.ипотекийн зүйлийн хэмжээ;
12.2.4.дуудлага худалдааг явуулах хугацаа, газар;



үнэ;

12.2.5.дуудлага худалдааны анхны

12.2.6.дэнчингийн хэмжээ;

12.2.7.холбоо барих хаяг, утас.

12.3.Дуудлага худалдааны зарын хэмжээ
сонинь нүүрийг найм хуваасны нэгээс багагүй
байна.

13 дугаар зүйл. Дуудлага худалдааг зохион байгуулахад эзэлдэгч хамтран ажиллах

13.1.Эзэлдэгч ипотекийн зүйлийн талаархи
шаардлагатай мэдээллийг эзэлдүүлэгчид өгөх,
сонирхогч этгээдийг ипотекийн зүйлтэй биечлэн
танилцах боломжоор хангах зэргээр дуудлага
худалдааг зохион байгуулахад хамтран ажиллах
үүрэгтэй.

14 дүгээр зүйл. Дуудлага худалдааны анхны үнэ

14.1.Дуудлага худалдааны анхны үнэ нь
зээлийн гэрээгээр тодорхойлсон зээлийн хэмжээ,
түүний хүүтэй тэнцүү байна.

15 дугаар зүйл. Дуудлага худалдаанд оролцогч

15.1.Дуудлага худалдаанд энэ хуулийн
15.2-т зааснаас бусад ипотекийн зүйлийг худалдан
авах сонирхол бүхий ямар ч этгээд оролцож болно.

15.2.Дараахь этгээд дуудлага худалдаанд
оролцохыг хориглоно:

15.2.1.зээлдүүлэгч болон түүний
төлөөлөгч;

15.2.2.зээлдүүлэгчийн хувь
нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга,
гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан, тэдгээрийн гэр
бүлийн гишүүн, тэдгээрт нийт хувьцааны 50-иас
дээш хувийг эзэмшүүлдэг хуулийн этгээд, түүний
охин компани;

15.2.3.ипотекийн зүйл нь Монгол
Улсын иргэнд өмчлүүлсэн газар байвал гадаадын
иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд.

16 дугаар зүйл. Дуудлага худалдаанд зээлдэгчийг оролцуулах

16.1.Зээлдэгч, эсхүл түүний төлөөлөгч
дуудлага худалдаанд ажиглагчаар оролцох эрхтэй.

16.2.Дуудлага худалдааг явуулахаас 10-аас
доошгүй хоногийн өмнө зээлдүүлэгч нь түүнийг
явуулах хугацаа, газрын талаар зээлдэгчид
мэдэгдэл хүргүүлэх үүрэгтэй бөгөөд ингэхдээ энэ
хуулийн 7 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.

16.3.Дуудлага худалдааг явуулах хугацаа,
газрын талаар энэ хуулийн 16.2-т заасан журмын
дагуу мэдэгдсэн боловч зээлдэгч хүрэлцэн ирээгүй
нь дуудлага худалдааг хүчин төгөлдөр бус гэж
тооцох үндэслэл болохгүй.

17 дугаар зүйл. Дуудлага худалдааг зохион байгуулах

17.1.Дуудлага худалдааг эзэлдүүлэгчийн
хүсэлтээр түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл
энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг этгээд
зохион байгуулна.

18 дугаар зүйл. Дуудлага худалдаа явуулах журам

18.1.Энэ хуулийн 15.1-д заасан дуудлага
худалдаанд оролцогч нь энэ хуулийн 12.2.6-д
заасан дэнчинг төлсөн байна.

18.2.Энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан
этгээд дуудлага худалдааг нээснийг мэдэгдэж,
түүнийг явуулах журам, худалдагдах ипотекийн
зүйлийн талаархи танилцуулга, анхны үнэ,
худалдах-худалдан авах гэрээний нөхцлийг уншиж
танилцуулна.

18.3.Зохион байгуулагч нь дуудлага
худалдааны анхны үнийг өсгөх саналын доод
хэмжээг тогтоож болно.

18.4.Оролцогч нь анхны үнийг өсгөх саналыг
гаргаснаар дуудлага худалдааны үнэ хаялцуулах
ажиллагаа эхэлнэ.

18.5.Дуудлага худалдааны үнэ хаялцуулах
ажиллагааг амаар явуулж, тэмдэглэл хөтлөнө.

18.6.Зохион байгуулагч нь сүүлийн үнийг
зарлаж, гурван удаа дуудсаны дараа дуудлага
худалдааны үнэ хаялцуулах ажиллагаа дуусгавар
болно.

18.7.Дуудлага худалдаанд хамгийн өндөр
үнийн санал хэлсэн этгээд ялагч болно.

18.8.Ялагчтай худалдах-худалдан авах
гэрээ байгуулна.



18.9.Зохион байгуулагч нь ялагч, түүний хэлсэн үгийн саналыг оролцогчдод танилцуулах ба энэ хуулийн 18.14-т заасан төлбөрийг 14 хоногийн дотор төлөх, төлөөгүй тохиолдолд дэнчингээ алдах талаар ялагчид заавал сануулна.

18.10.Дуудлага худалдааны тэмдэглэлд зохион байгуулагч, ялагч нар гарын үсэг зурна.

18.11.Ялагч нь тэмдэглэл болон худалдах-худалдан авах гэрээнд гарын үсэг зурсанаар дуудлагыг худалдааг явагдсанд тооцно.

18.12.Ялагч тэмдэглэл болон худалдах-худалдан авах гэрээнд гарын үсэг зурахаас зайлсхийвэл тавьсан дэнчингээ алдана.

18.13.Ялагчаар шалгарч чадаагүй оролцогчийн энэ хуулийн 18.1-д заасан журмын дагуу төгссөн дэнчинг түүнд буцаан олгоно.

18.14.Ялагч нь дуудлага худалдаа явагдсанаас хойш 14 хоногийн дотор үлдсэн төлбөрийг төлж дуусгах үүрэгтэй.

19 дүгээр зүйл. Орлого хуваарилах

19.1.Ипотекийн зүйлийг худалдан борлуулсны орлого нь үндсэн үүргийн гүйцэтгэлээс илүү гарсан бол ийнхүү давсан хэсгийг эзэлдэгчид буцаан олгоно.

20 дугаар зүйл. Дуудлага худалдааг явагдаагүйд тооцох

20.1.Дуудлага худалдааны явцад өрсөлдөгч гараагүй, эсхүл энэ хуулийн 16.2-т заасан журмын дагуу эзэлдэгчид дуудлага худалдааны талаар урьдчилан мэдэгдээгүй бол түүнийг явагдаагүйд тооцно.

21 дүгээр зүйл. Дуудлага худалдааг дахин зарлах

21.1.Энэ хуулийн 20.1-д заасан үндэслэл байгаа, эсхүл ялагч энэ хуулийн 18.14-т заасан төлбөрийг төлөөгүй бол дуудлага худалдааг дахин нэг удаа зарлана.

21.2.Дуудлага худалдааг дахин зохион байгуулахад энэ хуулийн 14-19 дүгээр зүйлд заасан журмыг баримтлах бөгөөд дуудлага худалдааны зарыг 14-өөс доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу нийтэлнэ.

22 дугаар зүйл. Ипотекийн зүйлийг ялагчийн өмчлөлд шилжүүлэх

22.1.Ялагч нь ипотекийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэх тухай хүсэлтийг Эрхийн улсын бүртгэлийн албанд гаргах бөгөөд түүнд дараахь зүйлийг хавсаргана:

22.1.1.худалдах-худалдан авах гэрээний хувь;

22.1.2.дуудлага худалдааны зар;
22.1.3.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу эзэлдэгчид мэдэгдэл хүргүүлсэнийг нотлох баримт;

22.1.4.дуудлага худалдааг зохион байгуулах үед эзэлдэгч үүргээ гүйцэтгээгүй байсныг болон энэ хуулийн 15.2-т заасан зөрчил байхгүйг нотолсон дуудлага худалдаа зохион байгуулагчийн албан бичиг;

22.1.5.дуудлага худалдааны тэмдэглэл;

22.1.6.ялагч 14 хоногийн дотор энэ хуулийн 18.14-т заасан төлбөрийг төлснийг нотлох баримт.

22.2.Ипотекийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэх тухай ялагчийн гаргасан хүсэлт, түүнд хавсаргасан баримт нь энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан бол эрхийн улсын бүртгэгч ажлын гурван өдөрт багтаан худалдан борлуулах ажиллагааны бүртгэлийг хааж, өмчлөх эрхийг ялагчийн нэр дээр шилжүүлсэн тэмдэглэлийг улсын бүртгэлд оруулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Ипотекийн зүйлийг эзэлдүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх

23 дугаар зүйл. Зээлийн үүрэг гүйцэтгэх тухай эцсийн шаардлага

23.1.Энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу дуудлага худалдааг дахин зохион байгуулсан боловч ялагч тодроогүй бол эзэлдүүлэгч үүргээ гүйцэтгэх тухай эцсийн шаардлагыг эзэлдэгчид тавина.

23.2.Зээлдэгч үүргээ гүйцэтгэх эцсийн хугацаа нь эцсийн шаардлага хүлээн авснаас хойш 30 хоног байна.



23.3.Зээлдүүлэгч эцсийн шаардлагыг гардуулахдаа энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.

24 дүгээр зүйл. Эцсийн шаардлагын хугацаанд үүрэг гүйцэтгэх

24.1.Энэ хуулийн 23.2-т заасан хугацаанд үүргээ гүйцэтгэсэн зээлдэгч ипотехийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааг зогсоох тухай хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамтаар Эрхийн улсын бүртгэлийн албанд ажлын гурван өдөрт багтаан гаргана.

24.2.Зээлдэгч энэ хуулийн 23.2-т заасан хугацаанд үүргээ гүйцэтгэхдээ үүргийн гүйцэтгэлийн хэмжээг зээлдүүлэгчтэй харилцан тохиролцон багасгаж болно.

24.3.Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуулийн 24.1-д заасан зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн ажлын гурван өдөрт багтаан худалдан борлуулах ажиллагааны бүртгэлийг хааснаар уг ажиллагаа зогсоно.

24.4.Ипотехийн зүйл нь Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газар бөгөөд зээлдэгч энэ хуулийн 23.2-т заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол зээлдүүлэгч Эрхийн улсын бүртгэлийн албанд хүсэлт гаргаж, худалдан борлуулах ажиллагааны бүртгэлийг хаалгах үүрэгтэй.

25 дугаар зүйл. Зээлдүүлэгч ипотехийн зүйлийг өмчлөлдөө шилжүүлэх тухай хүсэлт гаргах

25.1.Зээлдэгч энэ хуулийн 23.2-т заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол зээлдүүлэгч Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газраас бусад ипотехийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэх тухай хүсэлтийг Эрхийн улсын бүртгэлийн албанд гаргана.

25.2.Ипотехийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэх тухай хүсэлтэд дараахь зүйлийг хавсаргана:

25.2.1.зээлдэгч нь энэ хуулийн 23.2-т заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй талаархи зээлдүүлэгчийн албан бичиг;

25.2.2.энэ хуулийн 23.1-д заасан эцсийн шаардлага гардуулсныг нотлох баримт;

25.2.3.дуудлага худалдааг хэрхэн зохион байгуулсан талаархи дуудлага худалдаа

зохион байгуулалчийн мэдэгдэл.

25.3.Ипотехийн зүйлийг өөрийн өмчлөлд шилжүүлэх тухай хүсэлт, түүнд хавсаргасан баримт нь энэ хуулийн 25.1, 25.2-т заасан нь шаардлагыг хангасан бол эрхийн улсын бүртгэгч ажлын гурван өдөрт багтаан судалдан борлуулах ажиллагааны бүртгэлийг хаах, өмчлөх эрхийг зээлдүүлэгчийн нэр дээр шилжүүлэн тэмдэглэлийг улсын бүртгэлд оруулна.

ЭРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

26 дугаар зүйл. Худалдан борлуулах ажиллагаатай холбогдсон зардал

26.1.Ипотехийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдон гарсан зардал болон нэмэгдүүлсэн хүү зэрэг бусад хохирлыг зээлдэгч хариуцна.

26.2.Зээлдүүлэгч энэ хуулийн 26.1-д заасан хохирлыг шүүхийн журмаар нэхэмжлэх эрхтэй.

27 дугаар зүйл. Худалдан борлуулах ажиллагаатай холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх

27.1.Ипотехийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад зээлдүүлэгч болон Эрхийн улсын бүртгэлийн алба энэ хуульд заасан журмыг зөрчсөн бол зээлдэгч нь шүүхэд гомдол гаргаж болох ба шүүх уг гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуухянан шийдвэрлэнэ.

27.2.Цүүх энэ хуулийн 27.1-д зааснаас өөр үндэслэлээр гаргасан гомдлыг хүлээн авахаас татгалзана.

27.3.Цүүх ипотехийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааг хүчингүй болгосон бол энэ хуульд заасан журмын дагуу дахин явуулна.

27.4.Зээлдүүлэгч нь энэ хуулийн 24.4-т заасны дагуу худалдан борлуулах ажиллагааны бүртгэлийг халгасан бол зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбогдсон асуудлыг шүүхээр шийдвэрлүүнэ.

28 дугаар зүйл. Ипотехийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль тогтоомж зорчигчид хүлээлгэх хариуцлага



28.1.Энэ хуульд заасан нотлох баримт, баримт бичгийг хурамчаар бүрдүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол иргэнийг 30000-50000, аж ахуйн нэгжийг 150000-250000, албан тушаалтныг 50000-60000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

29.1.Энэ хуулийг 2005 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуульд дор дурдсан агуулгатай 154.3, 154.4, 174.3, 174.4 дэх хэсэг тус тус нэмсүгэй:

1/154 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"154.3.Барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ.

154.4.Барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ."

2/174 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"174.3.Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан

борлуулахад энэ хуулийн 175.5- 175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй.

174.4.Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмыг хуулиар тогтооно."

2 дугаар зүйл. Иргэний хуулийн 171.3 дахь хэсгийн "хэлцэл" гэсний дараа "хуульд өөрөөр заагаагүй бол" гэж, 174.2 дахь хэсэгт "Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй." гэсэн 2 дахь өгүүлбэр, 453.2 дахь хэсэгт "Энэ заалт зөвхөн хөдлөх эд хөрөнгөнд хамаарна." гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Иргэний хуулийн 154.3- 154.6 дахь хэсгийн дугаарыг "154.5- 154.8" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТ ОУ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 2.1 дэх хэсгийн "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль" гэсний дараа ", Ипотекийн зүйлийг шүүхийн

бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль" гэж, 6.5 дахь хэсэгт "Энэ заалт эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн барьцааны үүрэг гүйцэтгүүлэгчид хамаарахгүй ба Эрхийн улсын бүртгэлийн алба тухайн барьцаатай холбогдсон

мэдээллийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өгнө.” гэсэн 2 дахь өгүүлбэр тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20.1.5 дахь заалтыг “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуульд заасан үндэслэлээр барьцааны зүйлийг худалдан борлуулсан, эсхүл барьцаалагчийн өмчлөлд шилжүүлсэн бол,” гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 20.6 дахь хэсгийн

“барьцаалагчийн шийдвэр, гэрээг” гэснийг “барьцааны зүйлийг худалдан борлуулсан бол худалдан авагчийн хүсэлт, улсын ерөнхий бүртгэгчийн шийдвэрийг; барьцааны зүйлийг хуульд заасан журмын дагуу барьцаалагчид шилжүүлсэн бол барьцаалагчийн хүсэлт, улсын ерөнхий бүртгэгчийн шийдвэрийг тус тус” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7–ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай Арван хоёрдугаар бүлэг¹ нэмсүгэй:

“АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ”

Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа

132¹ дугаар зүйл. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх

132^{1.1}. Шүүх ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдолтой хэргийг энэ бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

132^{1.2}. Шүүх ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэхдээ энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг баримтлана.

132^{1.3}. Нэхэмжлэгч ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдолтой нэхэмжлэл гаргахдаа энэ хуулийн 57.1-д заасан тэмдэгтийн хураамжаас гадна дуудлага худалдааны анхны үнийн 5 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шүүхийн мэдэлд шилжүүлж, тусгай дансанд байршуулна.

132^{1.4}. Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангасан тохиолдолд энэ хуулийн 132^{1.3}-т заасан мөнгөн хөрөнгийг нэхэмжлэгчид буцан олгоно. Хэрэв шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй бол мөнгөн хөрөнгийг улсын орлого болгоно.

132^{1.5}. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагааг түдгэлзүүлэх тухай нэхэмжлэгчийн хүсэлтийг

үндэслэн шүүгч захирамж гаргана.

132^{1.6}. Шүүгч энэ хуулийн 132^{1.5}-д заасан захирамж гаргасан бол захирамжийн үүхийг нэхэмжлэгчид хүргүүлнэ. Уг захирамжийг үндэслэн ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаа тухайн хэргийг шүүхээс хянан шийдвэрлэж дуустал түдгэлзэнэ.

132^{1.7}. Шүүх ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах ажиллагаатай холбогдолтой хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэх ба энэхүү хугацааг сунгахгүй.

132² дугаар зүйл. Ипотекийн зүйлийг албадан чөлөөлүүлэх тухай хүсэлт гаргах

132^{2.1}. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулсан боловч эзэлдэгч түүнийг чөлөөлөхөөс татгалзвал албадан чөлөөлүүлэх тухай үүрэг гүйцэтгүүлэгч шүүхэд хүсэлт гаргана.

132^{2.2}. Үүрэг гүйцэтгүүлэгч энэ хуулийн 132^{2.1}-д заасан хүсэлтийг гаргахдаа үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, эсхүл тухайн үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч гэдгээ нотлох бусад баримтыг шүүхэд гаргаж өгнө.

132^{2.3}. Шүүх ипотекийн зүйлийг албадан чөлөөлөх тухай шийдвэрийг 3 хоногийн дотор гаргах ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба шийдвэрийг биелүүлнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

БАНК, ЭРХ БҮХИЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МӨНГӨН ХАДГАЛАМЖ, ТӨЛБӨР ТООЦОО, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1 дэх хэсэгт "өмчийнхөө газрыг зохих журмын дагуу иргэнд болон банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалах" гэсэн 27.1.4 дэх заалт нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1.3 дахь заалтын "барьцаалах" гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1.4-27.1.8 дахь заалтын дугаарыг "27.1.5- 27.1.9" болгон өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд дор дурдсан агуулгатай 47.3, 48.8 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

2 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 48.7 дахь хэсгийн "борлогдоогүй" гэсний дараа "Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газраас бусад" гэж нэмсүгэй.

1/47 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"47.3. Албадан дуудлага худалдаагаар худалдах үл хөдлөх эд хөрөнгө нь Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газар бол албадан дуудлага худалдаанд зөвхөн Монгол Улсын иргэн оролцоно.

3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.3, 47.4 дэх хэсгийн дугаарыг "47.4, 47.5" гэж, 48.8-48.13 дахь хэсгийн дугаарыг "48.9-48.14" гэж тус тус өөрчилсүгэй.

2/ 48 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

"48.8. Төлбөр авагч нь Монгол Улсын иргэн бол албадан дуудлага худалдаагаар борлогдоогүй Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрыг энэ хуулийн 48.7-д заасны дагуу төлбөр авагчид санал болгож болно."

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Дугаар 48

Улаанбаатар хот

2005 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 66 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Ц.Дамиран/-нд даалгасугай

1.Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

Улсын Их Хурлын 2005 оны 48 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ 2005-2008 ОНД ХУВЬЧЛАХ, ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Нэг.Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн зорилго

1.1.Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах гол зорилго нь өнгөрсөн жилүүдэд эхлэл нь тавигдсан дэд бүтцийн болон нийгмийн салбарт хийгдэж байгаа өөрчлөн байгуулалт, хувьчлалын ажлыг эрчимжүүлж эдгээр салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхийн хамт бусад салбарын төрийн өмчийг хувьчлах ажлыг үргэлжлүүлэхэд оршино.

1.2.Төрийн өмчийг 2005-2008 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл нь /цаашид "Үндсэн чиглэл" гэх/ салбар тус бүрд хувьчлал, өөрчлөн байгуулалтын талаар баримтлах төрийн бодлого, энэ ажлыг зохион байгуулах арга хэлбэр, баримтлах зарчмыг тодорхойлж байгаа стратегийн шинжтэй баримт бичиг бөгөөд энэхүү баримт бичгийг Монгол Улсын төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэд үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүрэгтэй.

1.3. Хувьчлалын бэлтгэл ажлын хүрээнд олон улсын байгууллагаас авсан хөнгөлөлттэй зээлийг хэрхэн төлүүлэх асуудлыг шийдвэрлүүлнэ.

Хоёр. Төрийн өмчийг хувьчлахад баримтлах нийтлэг зарчим

2.1.Төрийн өмчийг хувьчлахад дараахь нийтлэг зарчмыг баримтална:

2.1.1.эдийн засагт хувийн хэвшлийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх үндсэн дээр үйлдвэрлэлийн үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

2.1.2.тухайн салбарт дангаар ноёрхох байдлыг задлах, боломжтой зарим хэсэгт нь өрсөлдөөнт орчныг бий болгох;

2.1.3.гадаадын хөрөнгө оруулагчдыг хувьчлалд оролцуулах замаар Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг хэрэгжүүлэх эдийн засгийн нөхцөлийг хангахад тодорхой хувь нэмэр оруулах;

2.1.4.хувьчлагдах аж ахуйн нэгжийн өр аялагыг хувьчлах үед нь байгууллага нэг бүрээр шийдвэрлэх;

2.1.5.төрөөс аж ахуйн үйл ажиллагаанд оролцох оролцоог багасгах, улсын төсвийн бүтцийг оновчтой болгох, үр өгөөжийг нь дээшлүүлэх;

2.1.6.төрийн зохицуулалтын үүргийг аж ахуйн үйл ажиллагаанаас тусгаарлаж, зохицуулах үүрэг бүхий байгууллагын хараат бус байдлыг хангах;

2.1.7.хувьчлалын үр дүнд гарч болох нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон сөрөг үр дагаврыг багасгах;

2.1.8.байгаль орчин, аюулгүй байдлыг хамгаалах;

2.1.9.гадаад, дотоодын хуулийн этгээд, иргэнд өр, төлбөртэй хуулийн этгээдийг хувьчлахаас өмнө нь зээлийн гэрээ нөхөн байгуулах, зээлийн гэрээтэй байгууллагуудын хувьд өр, зээлийн үлдэгдлийг баталгаажуулах, шаардлагатай өр, зээлийн буцаан төлөлтийн хугацаа, хүүгийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах замаар зээлийн бүтцийг өөрчилж, өнөөгийн үнэ цэнээр хувьчлалын дүнд тусган өртэй нь хамт хувьчлах, эсвэл хувьчлалын босго үнийн дүнд багтаан шууд төлүүлэх.

Гурав. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт

3.1. Үндсэн чиглэлийг дараахь зохион байгуулалтаар хэрэгжүүлнэ:

3.1.1. хувьчлалын явц, үр дүнгийн байдалд Улсын Их Хурлын холбогдох байнгын хороод хяналт тавих;

3.1.2. Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцын талаар Засгийн газрын тайланг Улсын Их Хурал жил бүр хэлэлцэж, чиглэл өгөх;

3.1.3. хувьчлах аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалт, энэхүү жагсаалтад орсон хөрөнгө /объект/-ийг хувьчлах арга, хэлбэрийг Засгийн газар жил бүр батлан гаргаж, Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах;

3.1.4. хувьчлах аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалтад орсон аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгө /объект/-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу хувьчлах ажлыг Төрийн өмчийн хороо эрхлэн явуулж, дүнг Засгийн газарт хагас жил тутам тайлагнах;

3.1.5. Үндсэн чиглэлд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагыг удирдлагын, гүйцэтгэлийн болон түрээсийн гэрээгээр ажиллуулах тухай Засгийн газрын шийдвэрийг Төрийн өмчийн хороо тухайн чиглэлийн /салбарын/ төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлж, явц, үр дүнг тодорхой хугацаанд хянан үзэж, Засгийн газарт мэдээлэх;

3.1.6. аж ахуйн нэгж, байгууллагын бүтцийн өөрчлөлтийн асуудлыг Төрийн өмчийн хороо тухайн чиглэлийн /салбарын/ төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэж, энэ тухай Засгийн газарт мэдээлэх.

Дөрөв. Өмч хувьчлалын арга, хэлбэр

4.1. Өмч хувьчлал/цаашид "хувьчлал" гэх/-д хувьчлалын уламжлалт аргуудыг хэрэглэхийн зэрэгцээ олон улсын уралдаант шалгаруулалт /тендер/, удирдлагын үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах, удирдлагын гэрээ, гүйцэтгэлийн гэрээ, түрээсийн гэрээ зэрэг арга, хэлбэрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын онцлог тохируулан дангаар буюу хослуулан хэрэглэнэ.

4.2. Төрийн эзэмшлийн хувьцааг шаардлагатай хэмжээгээр багцлан худалдах, нэмэлт хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх, алдагдалтай, цаашид ашигтай ажиллах боломжгүй аж ахуйн нэгжийг татан буулгаж, эд хөрөнгийг нь худалдах зэрэг өмч хувьчлалын арга, хэлбэрийг тухайн аж ахуйн нэгжийн онцлог тохируулан хэрэглэнэ.

4.3. Төрийн өмчийн аж ахуйн нэгжийг хувьчлахдаа ажилчдад "хувьцаа эзэмшүүлэх сан" хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Тав. Хувьчлалын талаархи мэдээлэл

5.1. Хувьчлалын талаархи мэдээллийг нийтэд адил тэгш, хүртээмжтэй хүргэж, хувьчлалыг ил тод явуулна.

5.2. Хувьчлалд оролцогч, хувьцаа эзэмшигч, сонирхогч этгээдийг шаардлагатай мэдээллээр хангах, чөлөөтэй, үндэслэлтэй сонголт хийх боломжийг бүрдүүлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгааг тогтмол явуулна.

5.3. Хувьчлалын талаархи мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн орчин үеийн техник, технологи ашиглан олон нийтэд өргөнөөр мэдээлэх ажлыг зохион байгуулна.

Зургаа. Хувьчлалын эрх зүйн орчин

6.1. Хувьчлалын талаар мөрдөж байгаа эрх зүйн актыг хувьчлалын талаар баримтлах төрийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгох арга хэмжээг дараахь чиглэлээр үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ:

6.1.1. орон нутгийн өмчийн удирдлага, зохицуулалт, хяналт, хувьчлалтай холбогдсон эрх зүйн харилцааг боловсронгуй болгох. Ингэхдээ нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг өргөтгөх, өмчийн удирдлага, бүртгэл, хяналт, бодлого, зохицуулалтыг оновчтой болгох;

6.1.2. дэд бүтэц, нийгмийн салбар дахь төрийн зохицуулалтыг аж ахуй, үйлчилгээний үйл ажиллагаанаас тусгаарлаж, зохицуулах үүрэг бүхий байгууллагын хараат бус байдлыг хангах;

6.1.3. аж ахуйн гэрээний эрх зүйн үндсийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

6.1.4. аж ахуй эрхлэгч төрийн байгууллагатай харилцан үр ашигтай хамтран ажиллах тогтолцоог төлөвшүүлэх.

Долоо. Дэд бүтцийн салбарт хийх хувьчлал, өөрчлөн байгуулалт

7.1. Дэд бүтцийн салбарт хувьчлал, өөрчлөн байгуулалт хийхдээ төрийн зохицуулалтын тогтолцоог зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцсэн хэлбэрт шилжүүлэх зарчим баримтална.

7.2. Тус салбарт хувьчлал хийхдээ хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, өрсөлдөөний

нөхцөлийг бий болгох, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогыг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдуулан явуулахыг иш үндэс болгоно.

Найм, Түлш, эрчим хүчний салбарт хийх хувьчлал, өөрчлөн байгуулалт

8.1. Хувьчлалын бэлтгэл хангах хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

8.1.1. Эрчим хүчний салбарт хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах зорилгоор зарим объектын хувьчлах аргын талаар томоохон хөрөнгө оруулагчдаас урьдчилан санал авах ажлыг хувьчлалын бэлтгэл ажлын хүрээнд ил тод, нээлттэй хийх замаар хувьчлалын арга хэлбэрийг сонгох;

8.1.2. Компани хоорондын өрийн томоохон сүлжээг арилгах, хэвийн биш өр авлагыг өнөөгийн үнэ цэнээр нь хувьчлалын дүнд тусган өртэй нь камт хувьчлах, зээлийн буцаан төлөлтийн хугацаа, хүүгийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах замаар хувьчлагдах аж ахуйн нэгжийн үнэ цэнийг өсгөх, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах;

8.1.3. Төрөөс олгодог, түүнчлэн хэрэглэгч хоорондын, салбар хоорондын татаасыг багасгах чиглэлд хэрэглэгч, нийлүүлэгч нарыг идэвхжүүлэх арга хэмжээ авах, тарифийг балансжуулах чиглэлээр тодорхой алхам хийх;

8.1.4. Хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө нөхөх эдийн засгийн орчныг бүрдүүлэх;

8.1.5. Хувьчлалын дараа гарах нийгмийн болон бусад төрлийн үр дагаврыг зөөлрүүлэх арга хэмжээг урьдчилан тооцсон байх;

8.1.6. Компанийн засаглалын дэвшилтэт зарчмуудыг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, алдагдлыг бууруулах, орлогоо хугацаанд нь авах чиглэлээр өнгөрсөн жилүүдэд хийж байсан ажлуудыг үргэлжлүүлэн хийх;

8.1.7. Хувьчлах объектийн хувьд байгаль орчны үнэлгээ хийгдсэн байх, ялангуяа хувьчлалын өмнө байгаль орчинтой холбоотой үүссэн асуудал байгаа эсэх, түүнийг шийдэх аргыг тодорхойлсон байх;

8.1.8. Хувьчлах тухайн байгууллалтын үйл ажиллагаа явуулах хүрээ /зах зээлийн хэмжээ/ нь тодорхой, тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлсэн байх.

3.2. Эрчим хүчний салбарын бүтээгдэхүүний үнийг Эрчим хүчний тухай хуульд заасан хэмжээнд зохицуулахдаа дор дурдсан арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

8.2.1. Эрчим хүчний үнийг зөв тогтоох үүднээс нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, түүний дотор удирдлагын болон зардлын бүртгэлийг боловсронгуй болгох чиглэлээр хийж байгаа ажлыг дуусгах;

8.2.2. Цагийн ялгавартай тариф, урьдчилсан төлбөртэй тоолуур нэвтрүүлэх замаар ачааллын зохицуулалтыг хангах, цахилгааны төлбөрийг цаг тухайд урьдчилан авах, хэрэглэгч ердийн тарифаас 2-3 дахин хямд цахилгаан авах бололцоог бүрдүүлэх;

8.2.3. Хэрэглээний онцлогоос үл хамаарсан ганц тарифт тогтолцоог өөрчлөх, хэрэглэж байгаа эрчим хүчний чадал, энерги, хугацаа, ачаалал зэргийг харгалзсан тарифийн ялгавартай тогтолцоо бий болгох;

8.2.4. Эрчим хүчний компаниудын хоорондын арилжааны харилцааг улам гүнзгийрүүлж нэг худалдан авагчтай загвараас контрактын болон свот зах зээлийн загварт шилжих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

8.2.5. Зохицуулах байгууллагын чадавхийг сайжруулж бие даасан байдлыг нь хангах;

8.2.6. Хувьчлалын дараа тодорхой бус байдлыг үүсгэхгүй байх, зохицуулалтын эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахын тулд зохицуулалтын бодлогыг ойлгомжтой, тодорхой, тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлэх;

8.2.7. Эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон аймаг, сум дахь төрийн болон орон нутгийн өмчид байгаа цахилгаан үйлдвэрлэх, түгээх хэсгийг хувьчлах чиглэл баримтлах.

8.3. Энэхүү Үндсэн чиглэлийн Хоёр дугаар бүлэгт заасан зарчмыг баримтлан зах зээлийн эрэлтэд нийцүүлэн дангаар буюу багцлах хэлбэрээр дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар дараахь аж ахуйн нэгжүүдийг хувьчилна:

8.3.1. Дулааны цахилгаан станц-2 ХК;

8.3.2. Дулааны цахилгаан станц-3 ХК;

8.3.3. Багануур ХК-ийн төрийн мэдлийн хувьцаа;

8.3.4. Багануур-Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ХК;

8.3.5. Шивээ-Овоо ХК-ийн төрийн мэдлийн хувьцаа;

8.3.6. Дарханы дулааны цахилгаан станц ХК;

8.3.7. Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ХК;

8.3.8. Улаанбаатарын дулааны дамжуулах сүлжээ ХК;

сүлжээ ХК;
 8.3.9. Дарханы дулааны дамжуулах
 8.3.10. Даланзадгадын ДЦС;
 8.3.11. Улаанбаатарын цахилгаан
 түгээх сүлжээ.

8.4. Эрчим хүчний тоног төхөөрөмж, туршилт тохируулгын үйлдвэрийг дуудлагын худалдаагаар хувьчилна.

8.5. Уул уурхайн салбарын олонхи аж ахуйн нэгж хувийн хэвшилд бүрэн шилжиж байгаатай холбогдуулан урьд үүссэн байгаль орчны эвдрэлийг нөхөн сэргээх асуудлыг Засгийн газраас тусгайлан авч үзэж, хувьчлагдаж аж ахуйн нэгжтэй хамтран шийдвэрлэх чиглэл баримтална.

Ес. Иргэний нисэхийн салбарт хийх хувьчлал, өөрчлөн байгуулалт

9.1. Иргэний нисэхийн салбарт хийх хувьчлалын бэлтгэлийг хангах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх үүднээс өөрчлөн байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

9.1.1. дотоодын нислэгийн чиглэлд нэмэгдэж байгаа хувийн хэвшлийн оролцоог дэмжих үүднээс иргэний нисэхийн үйлчилгээний үнэ тариф, нислэгийн чиглэл, хуваарийг либералчлах;

9.1.2. тус салбарт үйлчилгээ үзүүлэхэд ашиглаж байгаа төрийн өмчид бүртгэлтэй тоног төхөөрөмж ашиглалтаас хасагдаж шинээр хөрөнгө оруулалт шаардагдах тохиолдолд тухайн үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээг авах;

9.1.3. иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаа болон "МИАТ" хувьцаат компанийн хувьчлахтай холбогдуулан ИНЕГ-ын үндсэн үйл ажиллагааг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжийн техникийн аюулгүй байдлыг хянан баталгаажуулах, үйл ажиллагааг зохицуулах, нислэгийн аюулгүй байдлыг хангуулах үндсэн үүрэгтэй зохицуулагч байхаар өөрчлөн байгуулах ажлыг энэхүү Үндсэн чиглэлийн хэрэгжих хугацаанд үе шаттайгаар зохион байгуулах, үүнтэй уялдуулан мөрдөж байгаа Иргэний нисэхийн тухай хууль, эрх зүйн орчныг өөрчлөх;

9.1.4. "МИАТ" ХК-ийн өнөөгийн бий болж байгаа санхүүгийн болон компанийн засаглалын нааштай хандлагыг улам тогтворжуулах замаар хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах орчныг бүрдүүлэх;

9.1.5. "МИАТ" ХК-ийн бизнесийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлийг салгах замаар дотоодын нислэгийг хувийн салбарт шилжүүлэх;

9.1.6. "Агросервис" ХХК-ийг "МИАТ" ХК-ийн бүрэлдэхүүнээс салгаж хувьчлалын боломжит хэлбэрийг сонгон хувьчлах.

9.2. ИНЕГ-ын үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт орж байгаатай холбогдуулан үйлдвэрлэлийн дор дурдсан нэгжүүдийг эхний ээлжинд аж ахуйн тооцоонд оруулах, улмаар тус байгууллагын бүрэлдэхүүнээс гаргаж, бие даасан аж ахуйн нэгж болгон арилжааны хэлбэрт шилжүүлэх, цаашид хуульд заасан арга хэлбэрийн дагуу хувьчлах, хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

9.2.1. нисэх буудлууд;

9.2.2. барилга, сантехникийн засвар

үйлчилгээ;

9.2.3. шатахууны агуулах, хангах

үйлчилгээ;

9.2.4. ачаа, шуудан тээврийн

үйлчилгээний төв.

9.3. Хувьчлалын бэлтгэлийг хангахтай холбогдож хийгдэх дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлсний дүнд энэхүү Үндсэн чиглэлийн дунд хугацаанд "МИАТ" ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилна.

Арав. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хийгдэх хувьчлал, өөрчлөн байгуулалт

10.1. Холбооны салбарын хөгжилд сүүлийн үед гарч байгаа дэлхийн нийтлэг хандлагын дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хийгдэх хувьчлал, өөрчлөн байгуулалтад дараахь үндсэн чиглэл баримтална:

10.1.1. холбооны үйлчилгээний боломжтой зарим хэсэгт өрсөлдөөнт орчин бий болгох нөхцөлийг бүрдүүлэх;

10.1.2. сүлжээг ашиггүй зардал гарч байгаа зохисгүй үзэгдлийг зогсоох;

10.1.3. холбооны сүлжээнд чөлөөтэй, нээлттэй, ялгаварлалгүйгээр холбогдох боломжийг холбооны үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд тэгш олгох үүднээс холбооны суурь болон салбар шугамын ашиглалт, эзэмшлийг холбооны үйлчилгээ явуулах бизнес ажиллагаанаас салгаж сүлжээний бизнесийг дагнан эрхэлдэг болгох;

10.1.4. холбооны салбарт үйлчилгээ үзүүлж байгаа болон цаашид энэ салбарт бий болох аж ахуйн нэгжүүдэд сүлжээний бизнес эрхлэх зөвшөөрлийг дангаар нь олгох журамд шилжих;

10.1.5. холбооны салбар бүрэн

хэмжээгээр хувийн хэвшилд шилжиж байгаатай холбогдуулан алслагдсан нутаг дэвсгэр болон хувийн хэвшил дангаараа хүрэх бололцоо муутай зарим чиглэлд холбооны үйлчилгээг хүргэхэд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэх зорилго бүхий бүх нийтийн үүргийн санг бий болгох замаар холбооны үйлчилгээг сайжруулах;

10.1.6. "Монголын Цахилгаан Холбоо" ХК холбооны суурь сүлжээг онцгой эрхтэйгээр түрээсэлж байгааг зогсоох, тус компанийн үйл ажиллагааны чиглэлийг сүлжээний бизнесээс бусад бүх төрлийн холбооны үйлчилгээ явуулах эрхтэйгээр өөрчлөх;

10.1.7. "Монголын Цахилгаан Холбоо" ХК-д түрээсэлж байгаа төрийн өмчийн хөрөнгөнөөс монополийн шинжтэй суурь болон салбар сүлжээний хэсгийг тусгаарлан, түүнийг ашиглан зөвхөн сүлжээний үйлчилгээ явуулах бие даасан Төрийн өмчийн компанийг шинээр байгуулах;

10.1.8. төрийн өмчийн АТС-ууд болон түүнтэй холбоотой зарим хөрөнгөд дахин үнэлгээ хийж "Монголын Цахилгаан Холбоо" ХК-д шилжүүлэн төрийн өмчийн хувьцааг нэмэгдүүлэх, тус компанийн төрийн мэдлийн хувьцааг БНСУ-ын "Корей Телеком" компанид гэрээний дагуу эхэлж санал болгох, татгалзсан тохиолдолд олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

10.1.9. Нарны зайн үйлдвэрийн Олон улсын байгууллагаас авсан зээлийн өрийг шинэчлэн тооцож, түүнийг төлөх нөхцөлтэйгөөр дуудлагын худалдаагаар худалдах;

10.1.10. шуудангийн үйлчилгээний салбарт өрсөлдөөнт орчныг бий болгох, үндсэн сүлжээнд чөлөөтэй холбогдох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шуудангийн бүх нийтийн үйлчилгээний болон тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний нэр төрлийг тогтоон, шуудангийн сүлжээний харилцан холболтын журмыг мөрдүүлэх;

10.1.11. сүлжээний үйлчилгээг салгаж байгаатай холбогдуулан "Монгол шуудан" ХХК-ийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн зохион байгуулах;

10.1.12. "Монгол шуудан" компанийн үйл ажиллагаанд төр өөрийн мэдлийн хувьцаагаар дамжуулан хяналт тавих, дэмжлэг үзүүлэх боломжит хувилбарыг сонгон хувьчлах.

Арваннэг. Төмөр замын салбарт хийх өөрчлөн байгуулалт

11.1. Төмөр замын салбарт хийх өөрчлөн байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

11.1.1. төмөр замын салбарт зах зээлийн харилцааг гүнзгийрүүлж тус салбарын хууль, эрх зүйн орчныг өөрчлөн шинэчлэх замаар салбарын зохицуулалтын бие даасан тогтолцоо бий болгох;

11.1.2. Монгол-Оросын хамтарсан "Улаанбаатар төмөр зам" ХК-ийг анх байгуулсан үеийн Засгийн газар хоорондын гэрээ хэлцэл, компанийн дүрэм болон бусад шаардлагатай баримт бичгийг өнөөгийн нөхцөл байдал, дэлхийн нийтлэг хандлагуудад нийцүүлэн ОХУ-ын эрх бүхий этгээдтэй хамтран өөрчлөх;

11.1.3. дэлхийн нийтлэг хандлагын дагуу төмөр замын салбарын бололцоотой хэсэгт өрсөлдөөнт орчныг бий болгох зорилгоор галт тэрэгний үйл ажиллагааг замын дэд бүтцээс салгаж, аж ахуй эрхлэх зөвшөөрлийг тус тусад нь олгох замаар төмөр замын сүлжээнд зөвшөөрөл бүхий компаниуд адил нөхцөлөөр ажиллах бололцоог хангах. Үүнтэй холбогдуулан ОХУ-ын эрх бүхий этгээдтэй тохиролцсоны үндсэн дээр "Улаанбаатар төмөр зам" ХК-ийг галт тэрэгний, замын дэд бүтцийн, тээвэр зуучлалын болон бусад үйлчилгээний гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол-Оросын хамтарсан, бие даасан компаниуд болгон хуваах;

11.1.4. төмөр замын дэд бүтцийн үйл ажиллагааг бие даалгаж байгаатай холбогдуулан гадаад дотоодын этгээдүүдээс өөрийн эзэмшлийн ачааны болон суудлын вагоноор монголын төмөр замыг ашиглаж, үйлчилгээ явуулах бололцоог бий болгох;

11.1.5. Япон болон бусад хандивлагч орнуудаас Монгол Улсын Засгийн газарт олгосон зээл тусламж, Монголын талын хөрөнгөөр төмөр замын салбарт бий болсон хөрөнгийн өмчлөлийн асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, цаашид ийм төрлийн хөрөнгө оруулалт хийхдээ өмчлөлийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх журамд шилжих.

Арванхоёр. Нийтийн аж ахуйн салбарт хийх хувьчлал, өөрчлөн байгуулалт

12.1. Нийтийн аж ахуйн салбарт хийх хувьчлал, өөрчлөн байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

12.1.1. нийтийн аж ахуйн салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаатай уялдуулан энэ салбарт үйлчилж байсан төрийн зохицуулалтыг бие даасан зохицуулалтын тогтсголцонд шилжүүлэх өөрчлөлт хийх;

12.1.2. энэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг арилжааны горимд шилжүүлэх

үүднээс ойрын үед тэдгээрийг компанийн хэлбэрт шилжүүлэх;

12.1.3. тус салбарын боломжтой зарим хэсэгт өрсөлдөөний орчныг бий болгох зорилгоор цэвэр, бохир ус, дулааны нэгдсэн сүлжээгээр үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж нь дамжуулж байгаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, борлуулах, түгээх үйл ажиллагаа эрхлэхгүй, харин өөрийн шугамаар дамжуулахаас бусад тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид ижил нөхцөлөөр үйлчилгээ үзүүлж, зохицуулагчаас тогтоосон төлбөрийг авах журамд шилжих;

12.1.4. төслийн болон бусад тусламжийн хөрөнгөөр байгуулж байгаа худгуудын өмчлөлийн асуудлыг санхүүжүүлэгч байгууллагатай хамтран шийдвэрлэх;

12.1.5. нийтийн аж ахуй, үйлчилгээний салбарт хамаарах аж ахуйн нэгж, байгууллага орон нутгийн өмчид шилжсэн тул тус салбар дахь хувьчлал, өөрчлөн байгуулалтын асуудлыг тухайн орон нутгийн онцлогт тохируулан Үндсэн чиглэл болон тухайн жилд Засгийн газраас баталсан хөтөлбөр, чиглэлийг баримтлан Төрийн өмчийн хорсоотой зөвшилцсөний үндсэн дээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэрлэн явуулах.

Арвангурав. Тодорхой аж ахуйн нэгжийн хувьчлал

13.1. Дараахь аж ахуйн нэгжүүдийг Үндсэн чиглэлийн Хоёр дугаар бүлэгт заасан нийтлэг зарчмыг баримтлан дараахь байдлаар хувьчилна:

13.1.1. "Говь" ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар, стратегийн хөрөнгө оруулагчид хувьчлах;

13.1.2. "Булигаар" ХК-ийн Монгол банкинд төлөх өр болон хувьцааны эзэмшилтэй холбоотой зөрчлийг тодруулах, улмаар нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

13.1.3. "Монгол-Амикал" ХХК-ийн зарим тоног төхөөрөмжийг "Монгол тэмээний ноос" ТӨҮГ одоогоор ашиглаж байгааг харгалзан "Монгол-Амикал" ХХК-ийн өрийн асуудлыг шийдвэрлэсний дараа "Монгол тэмээний ноос" ТӨҮГ-ыг дуудлагын худалдаагаар худалдах;

13.1.4. "Дарханмахэкспо" ХК-ийн өмчлөлийн асуудлыг Япон улсын Засгийн газартай тохиролцож зохицуулсны дараа төрийн эзэмшлийн хувьцааг дуудлагын худалдаагаар худалдах;

13.1.5. "Ган тээрэм" ХК-ийг дуудлагын худалдаагаар худалдах;

13.1.6. "Монголболгаргео" ХХК-ийн Монголын талын хувийг ашигт малтмалын нөөцийн үлдэгдэлтэй нь уялдуулан дахин үнэгж эхний ээлжинд Болгар Улсын талд санал болгох замаар хувьчлах;

13.1.7. "Монголчехословакметалл" хамтарсан үйлдвэрийн Монголын талын хувийг ашигт малтмалын нөөцийн үлдэгдэлтэй нь уялдуулан дахин үнэгж эхний ээлжинд Чех Улсын талд санал болгох замаар хувьчлах;

13.1.8. "Дарханы төмөрлогийн үйлдвэр" ТӨҮГ-ын гадаад зээлийн өрийн үлдэгдлийг баталгаажуулан, үлдэгдлийн дүнгээр буцаан төлөлтийн гэрээ байгуулсны дараа олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

13.1.9. "Аэрогеодези" ТӨХК, "Зураг зүй" ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр технологийг шинэчлэх нөхцөлөөр нэмэлт хөрөнгө оруулалт хийх замаар хувьчлах, хөрөнгө оруулалт хийх этгээдийг уралдаант шалгаруулалтын аргаар шалгаруулах;

13.1.10. Геодези, зураг зүйн мэдээллийн санг төрийн өмчид үлдээж, нийтлэг журмаар ашиглах бололцоог хангах;

13.1.11. "Ховд цемент" ТӨҮГ-ыг дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулж, зээлийн өрийн үлдэгдлийг баталгаажуулан балансад нь тусгасны дараа хувьчлах;

13.1.12. Хөтөлийн "Цемент шохой" ТӨХК-ийн хувьчлалын бэлтгэл ажлын хүрээнд өрийн асуудлыг хөнгөлөх арга хэмжээ авсны дараа нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

13.1.13. "Монголросцветмет" нэгдлийг үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, удирдлагын бүтцийг оновчтой болгох, үр ашгийг дээшлүүлэх, тэдгээрийг түшиглэсэн хот, тосгодын соёл, боловсрол, үйлчилгээний зориулалттай нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх нөхцөлөөр хувьчлах, өөрчлөн байгуулах саналыг ОХУ-ын эрх бүхий этгээдэд тавьж зөвшилцөх;

13.1.14. "Эрдэнэ зам" ХК-ийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

13.1.15. "Авто импекс" ХК-ийн төрийн мэдлийн хувьцааг төсөвт төлөх гадаад болон дотоод зээлийн өрийн асуудалтай хамт авч үзэж, буцаан төлөлтийн гэрээ байгуулсны дараа хувьчлах.

Арвандөрөв. Санхүүгийн салбарын төрийн өмчийн байгууллагуудад хийх хувьчлал, өөрчлөн байгуулалт

14.1. Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн байгууллагуудын хувьчлал, өөрчлөн байгуулалтын талаар дараахь чиглэл баримтлана:

14.1.1. "Хадгаламжийн банк" -ийг олон улсын нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

14.1.2. "Капитал банк" дахь төрийн эзэмшлийн /8,72 хувь/ хувьцааг нийтийн дуудлагын худалдаагаар худалдах.

14.2 Үнэт цаасны зах зээл, Хөрөнгийн биржийн ажиллагааг хөнгөн шуурхай, уян хатан, өрсөлдөөнтэй болгох чиглэлээр дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ:

14.2.1. биржийн үйл ажиллагаанд банк болон мэргэжлийн бусад байгууллага оролцох боломжийг бүрдүүлэх;

14.2.2. жил бүр хувьчлагдах төрийн өмчийн компаниудын худалдах хувьцааны 50-иас доошгүй хувийг /200.0 сая төгрөгөөс доошгүй/ биржээр дамжуулан арилжих замаар түүний үйл ажиллагааг төрөөс дэмжих;

14.2.3. биржийн үйлчилгээний тарифийг эрэлт, нийлүүлэлтийн хэрэгцээнд нийцүүлэн оновчтой болгох;

14.2.4. биржээр арилжаалагддаг хувьцааны нэр хүндийг өсгөх, хувьцаагаа биржээр дамжуулан худалдах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор биржийн бүртгэлийн шаардлагыг шинэчлэн тогтоох, шаардлага хангахгүй байгаа биржээр хувьцаагаа арилжаалдаг компанийн нийтэд зарлан бүртгэлээс хасах. Компанийн үйл ажиллагааг нийтэд ил тод болгож, санхүү бүртгэлийн системээ сайжруулах шаардлагыг өндөржүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид сонголт зөв хийх боломж бүрдүүлж, хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэр олох магадлалыг нэмэгдүүлэх. Энэ чиглэлээр биржийн ажиллагааг сайжруулахад төрөөс тусалцаа үзүүлэх;

14.2.5. үнэт цаасны биржээс гадна үнэт цаас арилжаалах альтернатив зах зээл бий болгох, үүнтэй холбогдуулан тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

14.2.6. компанийн үнэт цаас, түүнчлэн Засгийн газрын болон орон нутгийн бонд зэрэг төрөл бүрийн үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхэд гол анхаарлыг төвлөрүүлж, энэ талаархи эрх зүйн болон арга зүйн зөвлөлгөө өгөх орчныг бүрдүүлэх ажиллагааг төрөөс дэмжих;

14.2.7. эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын санг арилжааны хэлбэрт шилжүүлэх, тус сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглах бололцоог бий болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх;

14.2.8. эрүүл мэндийн болон нийгмийн сайн дурын даатгалын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх;

14.2.9. нээлттэй тендер зарлах замаар Хөрөнгийн биржийн удирдах үйл ажиллагааг гадаадын менежментийн багаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

Арвантав. Нийгмийн салбарт хийх хувьчлал, өөрчлөн байгуулалт

Нийгмийн салбарт өөрчлөн байгуулалт, хувьчлалыг хийхдээ Монгол Улсын Их Хурлын 2002 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийг баримтална.

Арванзургаа. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хийх хувьчлал, өөрчлөн байгуулалт

16.1. Хувьчлал, өөрчлөн байгуулалтын хүрээнд боловсролын салбарт дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

16.1.1. төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны бие даасан байдлыг өргөтгөж, зарим сургуулийн чиглэлийг нь өөрчлөхгүйгээр, нэмэлт хөрөнгө оруулах нөхцөлтэйгөөр өөрчлөн зохион байгуулах ажлыг төрийн бодлоготой уялдуулан шийдвэрлэх;

16.1.2. суралцагсад, иргэдийг их, дээд сургууль, коллежийн үйл ажиллагааны талаархи мэдээллээр хангах үүднээс тодорхой үзүүлэлтээр зэрэглэл тогтоож, нийтэд мэдээлэх тогтолцоог бий болгох;

16.1.3. боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагуудын эзэмшил газарт тооллого явуулж, шинэчлэн баталгаажуулах;

16.1.4. боловсрол, шинжлэх ухааны байгууллагыг хотхоны хэлбэрээр хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх.

16.2. Соёл, урлагийн салбарыг өөрчлөн байгуулах чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

16.2.1. төсвийн зардлыг багасгах, үйл ажиллагааны үндсэн чиглэл болон үзэмэрийнх нь төрийн өмчийн харьяаллыг өөрчлөхгүй байх нөхцөлтэйгөөр зарим музейг тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус болон төрөлжсөн мэргэжлийн байгууллагад шилжүүлэх бодлогыг баримтлах;

16.2.2. Улсын цирк болон "Монгол кино" нэгтгэл ТӨҮГ-ын /Баримтат кино студийс бусад/ удирдах үйл ажиллагааг уралдаант шалгаруулалтаар

сонгосон удирдлагын багаар гүйцэтгүүлж, менежментийн үр дүнг харгалзан хувьчлах;

16.2.3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн орон нутгийн урлагийн байгууллагад хийх бүтцийн өөрчлөлтийг тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах.

16.3. Шинжлэх ухааны салбарын хувьчлал, өөрчлөн байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

16.3.1. корпорациудыг үйл ажиллагааных нь чиглэлийг өөрчлөхгүй нөхцөлтэйгөөр оюуны өмчийн үнэлгээг харгалзан зөвхөн салбарын эрдэмтэн, судлаачдын багт хаалттай уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах;

16.3.2. арьс шир, модон эдлэлийн үйлдвэрлэлийн чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийн техник технологийг хөгжүүлэх, хандивлагч орнуудаас үзүүлж байгаа тусалцааны үр ашгийг сайжруулах зорилгоор "Армоно" корпорацийн арьс ширний үйлдвэрийг судалгаа-туршилтын төв болгон байранд нь үлдээж, модны үйлдвэрийг байрных нь хамт ШУТИС-д шилжүүлэн, мод боловсруулах үйлдвэрийг нэгтгэн сургалт-судалгааны төв болгон зохион байгуулах.

Арвандолоо. Эрүүл мэндийн салбарт өөрчлөн байгуулалтын хүрээнд хийх ажил

17.1. Эрүүл мэндийн салбарын хувьчлал, өөрчлөн байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

17.1.1. улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг клиникийн эмнэлэг болон төрөлжсөн нарийн мэргэжлийн төвүүд, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түүнтэй адилтгах эмнэлгийн амбулатори, поликлиникт ажиллаж байгаа эмч нар өөрийн ажиллаж байгаа эмнэлэг, төв дотроо эмнэлгийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх;

17.1.2. эмнэлгийн туслах чанарын үйлчилгээг мэргэшсэн, төрөлжсөн байгууллагуудаар гүйцэтгэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах, ингэхдээ үйлчилгээгээр төрөлжсөн аж ахуйн нэгжийн хэлбэрээр хөгжүүлэх нөхцөл, боломжийг судлан тогтоох;

17.1.3. өрхийн эмнэлгийн статусыг тодорхой болгох, нөхөн сэргээх болон нэмэлт үйлчилгээг төлбөртэй болгох асуудлыг судлан шийдвэрлэх;

17.1.4. өрхийн эмнэлэгт барилга, тоног төхөөрөмжийг гүйцэтгэлийн гэрээгээр эзэмшүүлэх журамд шилжих;

17.1.5. Шастиний нэрэмжит III эмнэлгийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад нэмэлт хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэйгөөр, удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах;

17.1.6. Клиникийн I, II эмнэлэг болон "Биотехнологийн үйлдвэр, судалгаа, сургалтын төв"-ийн удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх;

17.1.7. "Хужирт", "Шаргалжуут" рашаан сувиллын газруудыг үйлчилгээний чиглэлийг нь өөрчлөхгүйгээр нэмэлт хөрөнгө оруулалт хийх нөхцөлтэйгөөр уралдаант шалгаруулалтын аргаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад хувьчлах;

17.1.8. "Монголэмимпекс" ХК-ийн гадаад зээлийн өрийн үлдэгдлийг баталгаажуулан, үлдэгдлийн дүнгээр буцаан төлөлтийн гэрээ байгуулсны дараа төрийн мэдлийн хувьцааг эм ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн хүрээнд хязгаартай дуудлагын худалдаагаар худалдах;

17.1.9. Эх нялхсын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн түрээсээр ашиглуулж байгаа хуучин байруудыг тэдгээрт оруулсан хөрөнгө оруулалтын тооцон дуудлагын худалдаагаар худалдах;

17.1.10. нийслэлийн зарим дүүргийн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт болон үйл ажиллагааг төрөлжүүлэх чиглэлээр өөрчлөх асуудлыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран шийдвэрлэх;

17.1.11. төв лабораторийг нь оролцуулахгүйгээр "Оргил" рашаан сувиллыг удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлах.

Арваннайм. Биеийн тамир, спортын салбарын өөрчлөн байгуулалт

18.1. Биеийн тамир, спортын салбарын өөрчлөн байгуулалтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

18.1.1. Биеийн тамир спортын төв ордныг зориулалтынх нь дагуу ашиглах, улсын төсвийн санхүүжилтийг хэмнэх нөхцөлтэйгөөр удирдах үйл ажиллагааг нь удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх;

18.1.2. төрийн өмчийн биеийн тамир, спортын заал, танхимуудыг зориулалтынх нь дагуу ашиглах нөхцөлтэйгөөр уралдаант шалгаруулалтын аргаар мэргэжлийн клубуудад хувьчлах.



Арванес. Бусад аж ахуйн нэгж, байгууллага, үл хөдлөх хөрөнгийн хувьчлал

19.1.Энэ Үндсэн чиглэлд дурдсанаас бусад салбарт төрийн өмчийг хувьчлахад дараахь зарчмыг баримтална:

19.1.1.хувьчлалд хамрагдах аж ахуйн нэгж, эд хөрөнгийн нэр төрөл, хэмжээ, хувьчлах арга хэлбэрийг үйл ажиллагааных нь онцлог байдал, улс орны эдийн засагт үзүүлэх нөлөөлөл зэргийг харгалзан Засгийн газар шийдвэрлэх;

19.1.2.тухайн жилд хувьчлах аж ахуйн нэгжийг сонгохдоо улсын төсөвт оруулах

орлого, хувьчлалын бэлтгэл хангагдсан байдлыг үндэслэх;

19.1.3.гадаад орнуудаас Монгол Улсын Засгийн газарт олгосон тусламж, хөнгөлөлттэй зээлийг ашиглаж байгаа аж ахуйн нэгжийн тухайд эзэл, тусламжийн асуудлыг шийдвэрлэсний дараа хувьчлах асуудлыг шийдвэрлэх;

19.1.4.төрийн өмчит үйлдвэрийн газрыг Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулсны үндсэн дээр хувьчлах.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 8 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,4-т заасныг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөрөө хүсэлт гаргасан Дамдинсүрэнгийн Оюунхүүг Архангай аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Санжаажавын Дорждагвыг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчийн, өөр ажил, албан тушаалд томилогдох болсон Амгалангийн

Насандэлгэрийг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Сандагийн Цэцэгмааг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Тогоочийн Дэлгэрмааг Өмнөговь аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2005 оны 6 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 147

Улаанбаатар хот

Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг 1 дүгээр хавсралт ёсоор, Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ойд арчилгаа хийж, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүү бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус тогтоосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай"

Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 163 дугаар тогтоол, "Төлбөрийн болон түүний хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1996 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 312 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

У.БАРСБОЛД

Засгийн газрын 2005 оны 147 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ОЙГООС ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

A	Модны үүлдэр	Хэмжээ ногж	Мод тээврийн зай 50 км хүртэл				Мод тээврийн зай 51-100 км			
			Хэрэглээний модны хэмжээ			Түлээ	Хэрэглээний модны хэмжээ			Түлээ
			том	дунд	жижиг		том	дунд	жижиг	
	1	2	3	4	5	6	7	8	9	10
Нэгдүгээр муж										
1	Гацуур, жодоо	M ³	26000	21700	17800	6000	16000	13300	11000	3700
2	Нарс	M ³	22900	19100	15700	5300	14100	11700	9600	3300
3	Шинэс	M ³	18400	15300	12500	4250	11300	9400	7700	2600
4	Хус	M ³	11000	9200	7500	2500	6800	5600	4600	1600
5	Улиас, улиангар	M ³	9400	7800	6400	2200	5800	4800	3900	1400
6	Бургас	M ³	-	-	6900	600	-	-	4600	400
7	Харгана	M ³	-	-	-	2000	-	-	-	1400
8	Заг	тн	-	-	-	9400	-	-	-	6200
9	Бусад бут сөөг: хармаг, буйлс г.м	M ³	-	-	-	3100	-	-	-	2100
Хоёрдугаар муж										
1	Гацуур, жодоо	M ³	15850	13200	10800	3500	9800	8100	6800	2200
2	Нарс	M ³	13900	10800	8900	2900	7800	6500	5300	1800
3	Шинэс	M ³	11200	9300	7600	2500	6900	5700	4700	1600
4	Хус	M ³	6700	5600	4600	1500	4100	3400	2850	1000
5	Улиас, улиангар	M ³	5700	4750	3900	1300	3500	2900	2400	800
6	Бургас	M ³	-	-	4700	500	-	-	3100	400
Гуравдугаар муж										
1	Гацуур, жодоо	M ³	13900	11600	9500	3100	6800	5700	4700	1400
2	Нарс	M ³	11300	9450	7750	2500	5450	4550	3700	1200
3	Шинэс	M ³	9800	8150	6700	2200	4800	4000	3300	1000
4	Хус	M ³	5900	4900	4100	1300	2900	2400	2000	600
5	Улиас, улиангар	M ³	5200	4200	3400	1100	2450	2050	1700	500
6	Бургас	M ³	-	-	4700	500	-	-	3100	400
Дөрөвдүгээр муж										
1	Гацуур, жодоо	M ³	11900	9900	8150	2650	5900	4900	4000	1200
2	Нарс	M ³	9900	8300	6800	2200	4900	4000	3350	1000
3	Шинэс	M ³	7900	6600	5400	1750	3900	3300	2650	800
4	Хус	M ³	4800	4000	3300	1100	2350	2000	1600	500
5	Улиас, улиангар	M ³	4000	3400	2750	950	2000	1650	1350	400
6	Бургас	M ³	-	-	4000	500	-	-	2650	400
Тайлбар: Бэлтгэсэн модны нарийн үзүүрийн голч нь 25.0 см-ээс дээш бол том, 13.0-24.5 см бол дунд, 3.0-12.5 см бол жижиг хэрэглээний модонд тус тус тооцно.										
A	Модны үүлдэр	Хэмжээ ногж	Мод тээврийн зай 101 км-ээс дээш			Түлээ				
			Хэрэглээний модны хэмжээ							
			Том	дунд	жижиг					
	1	2	3	4	5	6				
Нэгдүгээр муж										
1	Гацуур, жодоо	M ³	10150	8300	6950	2800				
2	Нарс	M ³	9000	7300	6100	2500				
3	Шинэс	M ³	7100	5800	4900	2000				
4	Хус	M ³	4300	3500	2900	1200				
5	Улиас, улиангар	M ³	3650	3000	2500	1000				
6	Бургас	M ³	-	4600	3850	400				
7	Харгана	M ³	-	-	-	1400				
8	Заг	тн	-	-	-	6300				
9	Бусад бут сөөг: Хармаг, буйлс г.м	M ³	-	-	-	2100				

A	1	2	3	4	5	6
Хоёрдугаар муж						
1	Гацуур, жодоо	M ³	5900	4950	4050	1250
2	Нарс	M ³	5200	4350	3600	1100
3	Шинэс	M ³	4200	3500	2850	900
4	Хус	M ³	2500	2100	1700	500
5	Улиас, улиангар	M ³	2150	1800	1450	450
6	Бургас	M ³	-	-	3100	300
Гуравдугаар муж						
1	Гацуур, жодоо	M ³	3900	3250	2650	700
2	Нарс	M ³	3000	2500	2100	600
3	Шинэс	M ³	2750	2300	1900	500
4	Хус	M ³	1650	1400	1150	300
5	Улиас, улиангар	M ³	1400	1200	1000	250
6	Бургас	M ³	-	-	3150	300
Дөрөвдүгээр муж						
1	Гацуур, жодоо	M ³	2000	1650	1350	600
2	Нарс	M ³	1600	1400	1100	500
3	Шинэс	M ³	1300	1100	900	400
4	Хус	M ³	800	650	550	300
5	Улиас, улиангар	M ³	700	550	450	200
6	Бургас	M ³	-	-	2700	300

Тайлбар: Бэлтгэсэн модны нарийн үзүүрийн голч нь 25.0 см-ээс дээш бол том, 13.0-24.5 см бол дунд, 3.0-12.5 см бол жижиг хэрэглээний модонд тус тус тооцно.

Засгийн газрын 2005 оны 147 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА ОЙД АРЧИЛГАА ХИЙЖ, ХОЖУУЛ, УНАНГИ, ҮЗҮҮР, МӨЧИР, ГИШҮҮ БЭЛТГЭХ ЗЭРЭГ ОЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АРГААР ХЭРЭГЛЭЭНИЙ МОД, ТҮЛЭЭ БЭЛТГЭЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ ХӨНГӨЛӨХ ХУВЬ ХЭМЖЭЭ

д/д	Үзүүлэлтүүд	Х/н	Мужийн ялгаа, төлбөрийг хөнгөлөх хувь			
			1	2	3	4
1	Цэвэрлэгээний аргаар хожуул, унангийг түлээнд зориулан бэлтгэх	хувь	40	40	50	60
2	Цэвэрлэгээний аргаар үзүүр, мөчир, гишүүг ойгоос түүж бэлтгэх:					
	1. Иргэн, мод бэлтгэлийн бус аж ахуйн нэгж, байгууллага түлээ бэлтгэх	хувь	30	40	50	70
	а/ шилмүүст мод	хувь	20	30	40	50
	б/навчит мод	хувь	20	30	40	50
	2. Мод бэлтгэлийн байгууллага хэрэглээний мод, түлээ бэлтгэх	хувь	20	30	40	60
3	Насны хоёрдугаар ангиас дээш насны ойд арчилгаа хийх аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэх	хувь	20	30	40	60

Тайлбар:

1. Төлбөрийн хөнгөлөлтийн хувь хэмжээ нь мод тээврийн бүх зайд хамаарна.

2. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, хожуул, унанги, үзүүр, мөчир, гишүүг түүж бэлтгэх зэрэг ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь хэмжээ нь эрх бүхий байгууллага, гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, иргэнд хамаарна.